



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 06 сарын 15 өдөр

Дугаар А/372

Ховд


Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.1, 39.1.2, 39.1.4, 42 дугаар зүйлийн 42.1.1, 42.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй залуучуудыг нийгэмшүүлэх, оролцоог хангах, идэвхжүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй орчныг бүрдүүлэхэд олон нийт, ажил олгогчдыг уриалах зорилготой "Mongolian TRY" нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулахад 2,000,000 төгрөг (хоёр сая) -ийг хавсралтаар баталж зарцуулсугай.

2. Дээрх үйл ажиллагаанд шаардагдах 2,000,000 төгрөг (хоёр сая)-ийг орон нутгийн хөгжлийн сангийн төсөл арга хэмжээний 4.5-д тусгагдсан "Залуучуудын хөгжил" хөтөлбөрөөс тооцож санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Энхболд), Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ч.Багдал) нарт зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Т.Дэлгэрсайхан)-д даалгасугай.



Б.ДҮГЭРЖАВ

8400 01 1384